

*Г.Наранбаяр , ДХИС-ийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн удирдлага стратегийн багийн ахлах багш , хошууч*

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хураангуй: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2015 оны нэмэлт өөрчлөлтөөр хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах, хулгайлах, залилах, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, хууль бусаар мод бэлтгэх, алдуул мал, гээгдсэн хөрөнгө завших, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих зэрэг хөнгөн хэрэг үйлдсэн этгээдэд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах зохицуулалт орсон. Энэхүү ялыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх болсон. Уг ялыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүсэж буй нөхцөл байдал, анхаарах асуудлыг энэхүү өгүүлэлд дурдана.

Түлхүүр үг: Эрүүгийн хууль, хөнгөн ял, зорчих эрх, аюулгүй байдал, цахим гав,

Оршил: Монгол Улсын хэмжээнд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж байна. Уг ялын төрөл цоо шинэ зүйл биш бөгөөд 2015 онд Эрүүгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, зорчих эрхийг хязгаарлах ялыг оруулсан байдаг. Тодруулбал Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлийн 1.3 дахь заалтад Зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулж болохоор тусгасан юм. Үүнд хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах, хулгайлах, залилах, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, хууль бусаар мод бэлтгэх, алдуул мал, гээгдсэн хөрөнгө завших, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих зэрэг хөнгөн хэрэг үйлдсэн хүнд оногдуулахаар заасан байдаг.

Гэвч ялыг хэрэгжүүлэхтэй холбоотой программ хангамж, цахим гав нийлүүлэх болон бусад зардалд нийт 3,4 тэрбум орчим төгрөгний төсөв шаардагдах урьдчилсан судалгаа гарсан тул уг ялыг хэрэгжүүлэх үйл явц удааширсан байдаг. Түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхийн тулд тоног төхөөрөмжийг аль улсаас авах, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй эсэх зэрэг тал бүрийн судалгаанд багагүй цаг хугацааг зарцуулжээ.

Хэдийгээр өрнө, дорнын өндөр хөгжилтэй улс орны тоног төхөөрөмжийг судалж байсан боловч тэдгээр улсад ашиглаж буй цахим гав нэлээд өндөр өртөгтэй, цаг хугацаа шаардсан төхөөрөмж байсан учраас үнэ өртөг хэрэглэх программ хангамжийн хувьд БНХАУ-д ашиглаж буй төхөөрөмж илүү тохиромжтой гэж үзэж тус улсын бүтээгдэхүүнийг сонгосон байна.

Энэхүү өгүүлэлд зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүсэж буй нөхцөл байдал, харилцаа болон цаашид анхаарах асуудлыг хөндөх болно.

Ингэхдээ онол, арга зүйн үндэслэл болгож хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан ярилцлагад мониторинг хийх, баримт бичгийн судалгааны арга зүй, харьцуулалт, дүн шинжилгээ хийх аргачлал арга зүйг ашигласан болно.

Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт

Зорчих эрхийг хязгаарлах ял бол шинэ төрлийн ял биш. Түүхэн эх сурвалжаас үзвэл зорчих эрхийг хязгаарлах ялыг хүн төрөлхтөн нэн эртнээс оноож байжээ.

Эртний хятадын Чин династи /МЭӨ 221-206/-ийн үед хааны сурвалжит гэр бүлийн зарим гишүүнийг төрийн хэрэгт оролцуулахгүй байх үүднээс нутаг зааж, зорчих эрхийг хязгаарлах буюу гэрийн хорионд байх ялыг оноодог байж.¹ Хятадын хувьд хөл хорих явдал үндсэндээ улс төрийн хэрэгтний уламжлалт ялын төрөл байдаг. Тус улсад зорчих эрхээ хязгаарлуулсан маш олон тохиолдол бий. Тухайлбал, БНХАУ-ын Коммунист намын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Жао Зиан /Zhao Ziyang/-г 1989 оны Тяньминий талбайд болсон эсэргүүцлийн хөдөлгөөний дараа 16 жил гэрийн хорионд байлгаж, аялах, гольф тоглох зэрэг эрхийг хязгаарласан байдаг. Мөн SARS-ийн тохиолдлыг илрүүлсэн эмч Жианг Янён /Jiang Yanyong/ болон Түвдийн Гэлүгпагийн урсгалын Гэндэн Чой Нямааг цагдан хорьж, гэрийн хорионд байлгасан байдаг².

Манай хойд хөрш ОХУ-ын тухайд мөн адил II Николай хааныг эхнэр, дөрвөн охин, нэг хүүгийнх нь хамт 1918 оны 07 дугаар сарын 17-ны өдөр коммунистууд алахаас өмнө жил гаруй гэрийн хорионд байлгасан. Ерөнхий сайд асан Никита Хрущевыг 1964 онд огцорсны дараа долоон жилийн өмнө гэрийн хорионд байлгасан зэрэг цөөнгүй тохиолдол бий³.

Өрнөдийн улс орны тухайд гэрийн хорионд байлгах ялыг дундад зууны үеэс оноосон байдаг. Уг ялыг энгийн иргэдэд оноож байгаагүй, зөвхөн төрийн эргэлт хийхийг завдсан хааны удмын хүмүүсийг гэрт нь эсвэл нутаг зааж, олон нийтийн газраар зорчих, иргэдтэй уулзахыг хориглох зэрэг тодорхой хяналт, хязгаартайгаар хэрэгжүүлж байжээ. Харин 1633 оны 06 дугаар сарын 22-ны өдөр аугаа их одон оронч Г.Галилео /Galileo di Vincenzo Bonaiuti de' Galilei/ Католик шашны шүүхээр тэрс үзэлтэн хэмээн зарлаж, Флоренц хотоос холгүй орших Арцетри /Arcetri/ тосгонд гэрт нь хорих ялыг Ромын пап VIII Гэгээн хутагт оноосон байдаг⁴.

¹ "Out of Jail in China, but Not Free". Tatlow, Didi Kirsten. The New York Times, <https://www.nytimes.com/>

² Мөн тэнд

³ Семь лет «дачногорезима» для Хрущева KP.RU: <https://www.kp.ru/daily/25937.3/2883768/>

⁴ Galileo Faces Charges of Heresy - HISTORY, <https://www.history.com/this-day-in-history/galileo-in-rome-for-inquisition#:~:text=Galileo%20officially%20faced%20the%20Roman,dying%20on%20January%208%2C%201642.>

Түүхэн явцад энэхүү ял түгээмэл хэрэгждэг ялын төрөл байгаагүй. Гол төлөв улс төрийн хэрэгт оноодог ялын төрөл байжээ.

Орчин үеийн эрх зүйн ойлголтоор уг ялыг анх хэрэгжүүлсэн улс бол АНУ болно. Өөрөөр хэлбэл, тус улс 1983 оноос цахилгаан гав ашиглаж зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх болжээ.

Орчин үеийн эрх зүйн ойлголтоор зорчих эрхийг хязгаарлах гэдэг бол хөнгөн ялаар шийтгүүлсэн хүмүүсийг цахим хяналтын дор техникийн тусламжтай /цахим гав/-гаар зорчих эрхийг хязгаарлаж, нийгэмшиж гэр бүлтэйгээ байх техникийн шийдэл бүхий ялын төрөл болно.

Өнөөдөр манай хоёр хөрш орноос эхлээд дэлхийн 30 гаруй улсад зорчих эрхийг хязгаарлах ял үйлчилж байна. Эдгээр улсад цахим гавыг ашиглаж, хяналтыг дараах шат дарааллын дагуу гүйцэтгэж байна. Үүнд:

ШШГБ-д шүүхээс гаргасан тогтоолын хувийг илгээнэ;

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх ялтанд хэрэг бүртгэл нээнэ;

- Байнгын оршин суух хаяг, албан газар, хамаатан, найз нөхөд, ойр дотны хүний тухай мэдээллийг бүртгэнэ;

Эрүүл мэндийн үзлэгт хамруулна;

Тухайн этгээдэд цахим гав зүүж, хяналтын програмд бүртгэнэ;

Хяналтын төвөөс зорчих бүс хязгаарыг өөрчилж, анхааруулгыг мессежээр өгөх, шууд утсаар холбогдох зэрэг үйлдлийг төвөөс удирдана;

Гавыг тайлахыг оролдох, тогтоосон бүсээс оргон зайлах, санаатай болон санамсаргүй байдлаар төхөөрөмжийг цэнэглээгүй үйлдлийг хяналтын төвд бүртгэнэ;

Хугацаанаас өмнө суллах эсвэл сунгах, хорих ялаар сольж шийтгэх зэрэгт тухайн хэрэгтний хяналтын төвд байрших мэдээллийн санг үндэслэж прокурорт хүсэлт гаргадаг байна.¹

Манай улсад хорих болон хорихоос өөр ялын дөрвөн төрөл үйлчилдэг. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэж үздэг бол хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэж үздэг.

Монгол Улс зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн хүмүүст оноохоор төлөвлөсөн. Энэхүү ял хэрэгжснээр хүн ажил эрхэлж, гэр бүлтэйгээ байх боломж бүрдэж буй юм. Ингэснээр хорих зардлыг бууруулж, гурван тэрбум орчим төгрөг хэмнэх тооцооллыг гаргасан байна. Мөн хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хэрэгтнүүдийг нийгэмд хүмүүжүүлэх, сурч боловсрох, улмаар хөдөлмөр эрхлүүлж, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн барагдуулахад түлхүү ач холбогдолтой гэж үзжээ.

¹ *Understanding the Experience of House Arrest with Electronic Monitoring: An Analysis of Quantitative and Qualitative Data.* Randy R. Gainey, <https://doi.org/10.1177/0306624X00441008>

Монгол Улсын Эрүүгийн хуулинд Зорчих эрхийг хязгаарлах ялыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

1.Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.

2.Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно.

3 .Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

4 .Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно, түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ялын хугацааг нэг сараас таван жил гэж заасан бөгөөд гэмт хэрэгтний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар байдал зэргийг харгалзан ялын төрлийг шүүхээс сонгон хэрэглэхээр хуульчилсан байна.¹

Хоёр. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй шийтгүүлсэн өнөөгийн байдал, дүн шинжилгээ

Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн таван ялтан /Говь-Алтай аймагт 2, Орхон аймагт 2, Төв аймагт 1/ хяналтад байна. Үүнд:

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

1. Говь-Алтай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 2021/ШЦТ/06 дугаар шийтгэх тогтоолоор иргэн Д.Б-ийг Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 3 сарын хугацаанд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум, Тайшир сумын Галуут багийн нутаг дэвсгэрээс өөр газар явахыг хориглох, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчихгүй байх зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэжээ. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төвийн хэмжээгээр гарахыг хориглосон бүсийг зурж, /Тайшир сумын Галуут багт үүрэн холбооны сүлжээгүй учир зөвшөөрөгдсөн бүсэд оруулаагүй болно/ хяналт тавин ажиллаж байна.

¹Эрүүгийн хууль. <https://www.legalinfo.mn/law/details/11634>

2. Говь-Алтай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 2021/шцт/07 дугаар шийтгэх тогтоолоор иргэн О.Б-ийг Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 4 сарын хугацаанд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэрээс өөр газар явахыг хориглох, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчихгүй байх зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэсэн. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төвийн хэмжээгээр гарахыг хориглосон бүсийг зурж, хяналт тавин ажиллаж байна.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

3. Төв аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дүгээр шийтгэх тогтоолоор иргэн Д.О-ийг Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 1 сарын хугацаанд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүрэг хүлээлгэхээр шийтгэжээ. Ялтанг Төв аймгийн Зуунмод сумын төвийн хэмжээгээр гарахыг хориглосон бүсийг зурж, хяналт тавин ажиллаж байна.

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги:

4. Орхон аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 2021/ШЦТ/26 дугаар шийтгэх тогтоолоор иргэн Г.Б-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2-т заасны дагуу 3 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэж, Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрээс гарч явахыг хоригложээ.

5. Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 29 дүгээр шийтгэх тогтоолоор иргэн Б.Э-т Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 17.3.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт үйлдсэн гэмт буруутайд тооцож 2 жилийн хугацаанд Орхон аймгийн нутаг дэвсгэрээс явахыг хориглож шийдвэрлэсэн байна.¹

Мэдээллийн эх сурвалжаас үзвэл 2021 онд 1080 хүнд энэ шийтгэлийг оногдуулах урьдчилсан тооцоо гаргаж ийм тооны цахим бугуйвчийг бэлтгэсэн байна. Мөн оны өмнө бүх цахим бугуйвчийн тохиргоо болон туршилтыг хийж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба хаагч болон шүүх, прокурорын байгууллагын холбогдох хүмүүст сургалт, мэдээллийг өгч бэлтгэл ажлыг хангасан байна.

Гэтэл хууль хэрэгжсэнээс хойш 5 хүн зорчих эрхээ хязгаарлуулах ялыг эдэлж, “Цахим гав” зүүжээ. Дээрх таван тохиолдлыг авч үзвэл хөдөө орон нутагт, 1 сараас 2 жилийн хугацаанд цахим гав зүүлгэж, зорчих эрхийг хязгаарласан байна. Цахим гав буюу энэ бугуйвчны онцлог бол хориглосон бүсэд буюу очихыг хориглосон газар, объектод ойртсон, нэвтэрсэн тохиолдолд тухайн этгээдэд анхааруулга өгч, ШШГЕГ-ын “Ца.хим хяналт, удирдлагын төв-

¹ ШШГЕГ-ийн мэдээллийн сан

ийн хяналт тавьж байгаа ажилтанд дохио өгөх горимтой. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх явдал хорих зардлыг бууруулж, гурван тэрбум орчим төгрөг хэмнэх тооцооллыг гаргасан байна.¹

Хүний эрх, эрх чөлөөг дээлэх, ардчилал тэгш эрхийг бэхжүүлэх үүднээс “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Нэмэлт II Протокол”-д нэгдэн орох тухай хуулийг 2012 оны нэгдүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон баталснаар Монгол Улс цаазаар авах ялгүй орон болсон. Үүний дээр 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зорчих эрхийг хязгаарлах ял оноох болсон явдал хүний эрх, эрх чөлөөг дээдэлж буйн тод илрэл болно.

Аливаа үйл хэргийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд урьдач нөхцөл байдлыг бүрэн хангаж хийвэл хүрэх үр дүн илүү ач холбогдолтой байдаг. Зорчих эрхийг хязгаарлах ялыг ямарваа саад бэрхшээлгүй Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны аль ч нэгжид эдлүүлэх боломжийг хангах нь зөв. Иймээс Монгол Улсын бүхий л нутаг дэвсгэрийн хэмжээнд үүрэн утасны сүлжээнд бүрэн хамруулах ажлыг дэд бүтэц хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх хэрэгтэй.

Мөн цахим гавны үнэ <https://www.alibaba.com/showroom/prisoners-electronic-bracelet.html> цахим хуудас дээр 30-480 ам.доллар байна. Эх сурвалжид Монгол Улс БНХАУ-аас цахим гавыг ямар үнээр авсан талаарх мэдээлэл алга. Гэвч хамгийн доод буюу 30 ам.доллараар нэг бүрийг авсан бол зөвхөн цахим гавд 32.400 ам.доллар буюу 92.307.600 төгрөг зарцуулсан байна. Иймээс ухаалаг төхөөрөмжийг үндэсний компанид угсруулах, цаашид үйлдвэрлэх шаардлагатай юм,

Уг ялыг эдлүүлэхтэй холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа олонтаа дурдагдаж буй асуудал бол зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй этгээд хүмүүжих бус үйл хөдлөл, үг хэллэгээр хүчирхийлэл үйлдэх, сэтгэл зүйн дарамт үзүүлж буй эсэхийг хууль хяналтын байгууллага хэрхэн тогтоох вэ гэх асуулт байна. Учир нь Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх заалтад “...

1.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:

1.1.зодсон;

1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан;

1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;

2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;

¹Х.Нямбаатар: “Цахим гав”-ыг хэрэгжүүлснээр ГУРВАН ТЭРБУМ ТӨГРӨГ хэмнэнэ. <http://lnews.mn/9364/>

2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ хэмээн заасан¹ байгаагаар холбоотой.

Зорчих эрхийг хязгаарлах ял бол нэг төрлийн дахин нийгэмшүүлэх /rehabilitation/ болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл нийгмээс тусгаарлах бус харин нийгэмшүүлэх, хүмүүжүүлж төлөвшүүлэх арга хэмжээ болно. Иймээс ийм төрлийн ял эдэлж буй хүмүүст сурган хүмүүжүүлэх, зөв хандлага төлөвшүүлэх сургалтыг зайлшгүй хамтад нь явуулах хэрэгтэй болно.

Түүнчлэн цахим гав авилга, хээл хахуулийн хэрэгтэй нөлөө бүхий хүмүүст давуу байдал олгох вий гэх хардлага байна. Өөрөөр хэлбэл, төсвийн мөнгийг хувьдаа завших, авилга, хээл хахуулийн хэрэгт яллагдсан хэр “залилан” гэх нэрийдлийн дор 2-3 жилийн хугацаатай зорчих эрхийг хязгаарлах ял авах магадлал өндөр гэж үзэж байна. Энэхүү асуултад өгсөн албаны хариулт хангалтгүй байна. Тухайлбал, ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Д.Одсэр дээрх асуултад Эрүүгийн хуульд хорих болон хорихоос өөр төрлийн дөрвөн ял байдаг. Тэгэхээр гэмт хэрэг үйлдэн шүүхээс ял шийтгүүлж байгаа бүх хүн зорчих эрхээ хязгаарлуулна гэсэн үг биш. Гэмт хэрэгтний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар байдал зэргийг харгалзан шүүхээс ялын төрлийг сонгон хэрэглэх байх ...”² хэмээн хариулсан явдал олон нийтийн эргэлзээг бүрэн тайлж чадаагүй болно.

Дүгнэлт

Зорчих эрхийг хязгаарлах ял бол шинэ төрлийн ял биш. Түүхэн эх сурвалжаас үзвэл зорчих эрхийг хязгаарлах ялыг хүн төрөлхтөн нэн эртнээс оноож байсан болно.

Орчин үеийн эрх зүйн ойлголтоор зорчих эрхийг хязгаарлах гэдэг бол хөнгөн ялаар шийтгүүлсэн хүмүүсийг цахим хяналтын дор техникийн тусламжтай /цахим гав/-гаар зорчих эрхийг хязгаарлаж, нийгэмшиж гэр бүлтэйгээ байх техникийн шийдэл бүхий ялын төрөл болно.

Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, ардчилал тэгш эрхийг бэхжүүлэх үүднээс “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Нэмэлт II Протокол”-д нэгдэн орох тухай хуулийг 2012 оны нэгдүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон баталснаар Монгол Улс цаазаар авах ялгүй орон болсон. Үүний дээр 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зорчих эрхийг хязгаарлах ял оноох болсон явдал хүний эрх, эрх чөлөөг дээдэлж буйн тод илрэл юм.

¹ Эрүүгийн хууль. <https://www.legalinfo.mn/law/details/11634>

² Д.ОДСЭР: Цахим гав нь ус, чийгний хамгаалалттай, халуун хүйтэнд тэсвэртэй, ухаалаг систем <http://www.ncs.cd.gov.mn/?p=2595> 7

Энэхүү хууль хэрэгжсэнээс хойш 5 хүн зорчих эрхээ хязгаарлуулах ялыг эдэлж, “Цахим гав” зүүжээ. Дээрх таван тохиолдлыг авч үзвэл хөдөө орон нутагт, 1 сараас 2 жилийн хугацаанд цахим гав зүүлгэж, зорчих эрхийг хязгаарласан байна.

Уг ялыг эдлүүлэхтэй холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээлэл цөөнгүй гарч байна. Иймд уг хуулийг сурталчлах үнэн зөв ойлголт өгөх, ач холбогдлыг тайлбарлах шаардлагатай байна. Ялангуяа авилга, хээл хахуультай холбоотой хэрэгт уг ялыг оногдуулахгүй байх нь зөв.

Зорчих эрхийг хязгаарлах ял бол нэг төрлийн дахин нийгэмшүүлэх /rehabilitation/ болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл нийгмээс тусгаарлах бус харин нийгэмшүүлэх, хүмүүжүүлж төлөвшүүлэх арга хэмжээ болно. Иймээс ийм төрлийн ял эдэлж буй хүмүүст сурган хүмүүжүүлэх, зөв хандлага төлөвшүүлэх сургалтыг зайлшгүй хамтад нь явуулах шаардлагатай байна.